



ЕСӨНШИЖИР
ИНВЕСТ БАНК БУС САНХҮҮГИЙН
БАЙГУУЛЛАГА

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, АППЕТИТИЙН БОДЛОГО

Хувилбарын дугаар: 04

Баримт бичгийг хариуцах нэгж	Эрсдэлийн удирдлагын газар		
	Албан тушаал:	Нэр:	Гарын үсэг:
Боловсруулсан:	ЭУГ-ын захирал	Н.Оюун-Эрдэнэ	
Хянасан:	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, ахлах хуульч, комплайнсийн менежер	П.Ганбилэг	
Баталсан:	ТУЗ-ийн дарга	М.Гантулга	

2025 он



ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, АППЕТИТИЙН БОДЛОГО НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Зорилго

Есөн шижир инвест ББСБ (цаашид “ББСБ” гэх)-ын Эрсдэлийн удирдлага, аппетитийн бодлого (цаашид “Бодлого” гэх)-ын үндсэн зорилго нь ББСБ-ийн эрхэм зорилго, стратеги төлөвлөгөө, зорилтуудад нөлөө үзүүлж болзошгүй болон ББСБ-ийн хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлүүдийн аппетитын түвшинг тодорхойлж, үр дүнтэй удирдахад орших бөгөөд энэхүү зорилгын хүрээнд ББСБ нь дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ.

- 1.1.1 ББСБ нь стратеги, зорилгын хүрээнд хүлээж болзошгүй эрсдэл болон өгөөжийн хамгийн оновчтой түвшинг тооцоолон Эрсдэлийн аппетитийг тодорхойлж, түүний хүрээнд үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна.
- 1.1.2 ББСБ-ын гол эрсдэлийг илрүүлэх, үр дүнтэй удирдах, урьдчилан сэргийлэх эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгоход чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна.
- 1.1.3 ББСБ-ын эрсдэлийн удирдлагын тогтолцоонд оролцогчдын үүрэг, хариуцлагыг зохистой хуваарилсан байна. Эрсдэлийг илрүүлэх, тодорхойлох, үнэлэх, арга хэмжээ авах, хянах буюу эрсдэлийг удирдах үйл ажиллагааг дотоодын болон олон улсын стандарт, зөвлөмж, шилдэг туршлагын дагуу байнгын сайжруулалт хийж үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

1.2 Хамрах хүрээ

Энэхүү бодлогыг Төлөөлөн удирдах зөвлөл, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга, ББСБ-ын Гүйцэтгэх захирал, тэдгээрийн дэргэдэх Хороод, ББСБ-ын нийт ажилтан, албан хаагчид өөрсдийн үйл ажиллагаанд болон аливаа шийдвэр гаргалтад мөрдлөг болгоно.

1.3 Эрх зүйн байдал

- 1.3.1 Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, эрх бүхий буюу зохицуулагч байгууллагуудаас гаргасан аливаа дүрэм, журам, зөвлөмж, аргачлал болон эрх зүйн бусад актуудыг ББСБ-н эрсдэлийн удирдлагад мөрдлөг болгоно.
- 1.3.2 ББСБ-ын эрсдэлийн удирдлагад ББСБ-ын дүрэм, энэхүү бодлого, эдгээртэй уялдуулан гаргасан бусад бодлого, заавар, журмыг мөрдлөг болгоно.

1.4 Ёс зүйн хэм хэмжээ

Эрсдэлийг удирдах үйл ажиллагаанд ББСБ-ын ёс зүйн дүрмийг мөрдлөг болгож ажиллана.

1.5 Бодлогод нэмэлт өөрчлөлт оруулах

ББСБ-ын эрсдэлийн удирдлага хариуцсан газрын санал, Удирдлагын хорооны шийдвэрийг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталснаар энэхүү бодлогод нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн батлах бөгөөд нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн бодлого нь Монгол Улсын холбогдох хууль, тогтоомж, эрх бүхий болон зохицуулагч байгууллагаас гаргасан дүрэм, журам, компанийн дүрэмд нийцсэн байна.

1.6 Нэр томъёоны тайлбар

- 1.6.1 **Эрсдэл.** Мэдээллийн тодорхой бус байдлаас үүдэн ББСБ-н стратеги, зорилтуудад үзүүлэх сөрөг/ерэг нөлөөг ойлгоно.
- 1.6.2 **Эрсдэлийн удирдлага.** ББСБ-н эрхэм зорилго, стратеги төлөвлөгөө, зорилтуудад нөлөө үзүүлж болзошгүй болон ББСБ-ын хэвийн үйл ажиллагааны явцад сөргөөр нөлөөлөх эрсдэлүүдийг үр ашигтай удирдаж, хүлээж болзошгүй хохирол/алдагдлыг боломжит хамгийн бага түвшинд барих үйл ажиллагааг ойлгоно.
- 1.6.3 **Эрсдэлийн удирдлагын тогтолцоо.** Эрсдэлийн удирдлагыг төлөвлөх, хэрэгжүүлэх, мониторинг хийх, үнэлэх, тэдгээрийг тасралтгүй сайжруулах үйл ажиллагаанд чиглэсэн эрсдэлийн удирдлагын бодлого, зорилтууд, тэдгээрт тусгагдсан эрх, үүрэг болон эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө, нөөц бололцоо, хариуцлагыг ойлгоно.
- 1.6.4 **Эрсдэлийн аппетит.** Стратеги төлөвлөгөө, бизнесийн үйл ажиллагааг хэвийн хэрэгжүүлэхэд хүлээн зөвшөөрч болох эрсдэлийн төрөл болон түвшинг ойлгоно.
- 1.6.5 **Эрсдэлийн аппетитийн тунхаглал.** ББСБ бизнесийн зорилгоо биелүүлэхэд хүлээн зөвшөөрөх эсвэл зайлсхийх эрсдэлийн төрөл, түвшинг тодорхойлсон үзэл баримтлалын бичигдсэн зохицуулалтыг ойлгоно.
- 1.6.6 **Эрсдэлийн хязгаар.** ББСБ-ын эрсдэлийн аппетитаар тодорхойлсон эрсдэлийн нэр, төрөл бүрээр эрсдэлийг удирдахад зориулж тогтоосон хязгаарлалтыг ойлгоно.
- 1.6.7 **Эрх бүхий албан тушаалтан.** ББСБ-ын өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэхэд шаардлагатай шийдвэр гаргах эрх бүхий бөгөөд компанийн дүрмээр “эрх бүхий албан тушаалтан” гэж тодорхойлсон ажилтныг ойлгоно.
- 1.6.8 **Эрсдэл хариуцагч.** Эрсдэлийг удирдах үүрэг хүлээсэн, түүнтэй холбоотой шийдвэр гаргах эрх бүхий “Эрх бүхий албан тушаалтан”-г хэлнэ.
- 1.6.9 **Оролцогч тал.** Тухайн эрсдэлтэй холбоотой шийдвэр болон үйл ажиллагаанд оролцож буй хамаарал бүхий талуудыг ойлгоно.

ХОЁР. ЭРСДЭЛИЙН АППЕТИТ

2.1 Эрсдэлийн аппетитийг тодорхойлох



ББСБ нь эрсдэлийн аппетитийг үр ашигтай тодорхойлохын тулд дараах шаардлагуудыг удирдлага болгоно.

Үүнд:

- 2.1.1 ББСБ-ын стратеги төлөвлөгөө болон бизнесийн үйл ажиллагааны зорилтод нийцсэн, харилцагчдын ашиг сонирхлыг илэрхийлсэн, хувьцаа эзэмшигчийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхүйц, зохицуулагч байгууллагуудын шаардлагыг хангасан, бизнесийн үйл ажиллагаа хэвийн явагдах эрсдэлийн түвшнийг тооцож аппетитийг тодорхойлох;
- 2.1.2 Бизнесийн нэгжүүдийн хувьд ашиглаж болох, тоон үзүүлэлтээр хэмжигдэх эрсдэлийн хязгааруудыг тогтоох;
- 2.1.3 Нэр хүндийн болон үйл ажиллагааны эрсдэлээс хамгаалахад чиглэгдсэн чанарын үзүүлэлтийг багтаасан байх, тэдгээр эрсдэл бүрд хязгаарыг тогтоох;
- 2.1.4 Тооцоход хэт хүндрэлтэй, хоёрдмол утгатай болон ашиг сонирхлын зөрчил бүхий үзүүлэлтийг сонгохоос зайлсхийх;

2.2 Эрсдэлийн хязгаарыг тодорхойлох

- 2.2.1 ББСБ нь эрсдэлийн аппетитийг “Аюултай”, “Өндөр”, “Зохистой”, “Бага” гэсэн 4 түвшинд тодорхойлно.

Түвшин	Утга	Удирдлагын хариу
Бага (Target) Ногоон	Зорилтот, хэвийн үйл ажиллагаа	Ердийн хяналт
Зохистой (Appetite) Шар	Хүлээн зөвшөөрөх боломжтой	Тогтмол хяналт
Өндөр (Tolerance) Улбар шар	Хүлцэх дээд түвшин	Шуурхай арга хэмжээ
Аюултай (Limit) Улаан	Үл зөвшөөрөх	ТУЗ-д мэдэгдэж, засах

- 2.2.2 Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хувьд ББСБ-ын аппетит “Өндөр”, “Зохистой”, “Бага” байж болох хэдий ч “Бага” түвшинд барихыг эрмэлзэнэ.
- 2.2.3 “Өндөр” түвшиний эрсдэлийн хязгаарт хүрсэн эрсдэлийн аппетитад бага зохистой хэмжээ хүртэл хариу арга хэмжээ авч ажиллана.
- 2.2.4 Тухайн нэр төрлийн эрсдэлийн үзүүлэлт нь эрсдэлийн түвшинг “Өндөр” гэж үзэх дээд хязгаарыг давсан бол эрсдэлийн аппетитийг “Аюултай” түвшинд байна гэж тодорхойлох ба ББСБ ямар ч төрлийн эрсдэлийн хувьд “Аюултай” түвшний эрсдэлийг үл хүлээн зөвшөөрөх аппетиттай байна.

2.3 Эрсдэлийн аппетитийн тунхаглал

- 2.3.1 ББСБ нь стратеги төлөвлөгөө, бизнес зорилгын хүрээнд тодорхой нэр төрлийн эрсдэлийг Хавсралт 1 буюу Эрсдэлийн хязгаарын хүрээнд хүлээн зөвшөөрч ажиллана.
- 2.3.2 Энэхүү бодлогыг Хавсралт 1 буюу Эрсдэлийн хязгаарын гүйцэтгэлийг хэлэлцэх, эрсдэлийн хязгаарт өөрчлөлт оруулж, шинэчлэн батлах тухай асуудлуудыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн хороогоор шийдвэрлэнэ.


2.4 Эрсдэл хариуцагч

- 2.4.1 ББСБ-ын хэмжээнд үндсэн эрсдэл хариуцагч нь ББСБ-н Гүйцэтгэх захирал байна.
- 2.4.2 ББСБ-ын чиг үүргийн нэгжийн эрсдэл хариуцагч нь тухайн нэгжийн удирдлага буюу эрх бүхий албан тушаалтан байна.
- 2.4.3 Эрсдэл хариуцагч нь өөрийн хариуцсан нэгжийн эрсдэлийн удирдлагад мониторинг хийх буюу хяналт тавих бөгөөд эрсдэлийн аппетитад нийцүүлж ажиллана.

ГУРАВ. ЭРСДЭЛИЙН ЗАСАГЛАЛ

3.1 Эрсдэлийн удирдлага

- 3.1.1 ББСБ-ын эрсдэлийн удирдлага нь (1) эрсдэлийг таньж мэдэх, (2) эрсдэлд шинжилгээ хийх, (3) эрсдэлийг удирдах гэсэн үндсэн үйл ажиллагаанаас бүрдэх бөгөөд Зураг 1-т заасан агуулгатай байна.



Зураг 1/ Эрсдэлийн удирдлага

- 3.1.2 ББСБ нь дээрх шат дарааллын дагуу эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ эрсдэл бүрийг хариуцсан ББСБ-ын нэгж болон эх сурвалжаар нь ялгаж, тухай бүрд тохирсон удирдлагыг хэрэгжүүлдэг байна.
- 3.1.3 ББСБ хэвийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, учирсан эрсдэлийг арилгах, түүнийг засаж сайжруулах зорилгоор шат дараалсан хяналтын тогтолцоог хэрэгжүүлнэ.
- 3.1.4 ББСБ-ын эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа нь ББСБ-ын үйл ажиллагааны бүх чиглэлийг хамарсан, ББСБ-ын эрх бүхий албан тушаалтан, газар, нэгж тус бүрийн үйл ажиллагааны чиг үүрэгт тусгагдсан илрүүлэх, тодорхойлох, хэмжих, үнэлэх, бууруулах, хянах үйл ажиллагаанаас бүрдэх бөгөөд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд дараах 4 түвшний хяналтыг тавина. Үүнд:

3.1.4.1 Нэгдүгээр түвшин буюу Салбарын захирал болон ажилтнууд.

3.1.4.2 Хоёрдугаар түвшин буюу (i) Эрсдэлийн удирдлага хариуцсан нэгж, (ii) Захиргаа, эрх зүй хариуцсан нэгж, (iii) Комплаенс хариуцсан ажилтан, (iv) Дотоод хяналт хариуцсан нэгжийн хяналт

3.1.4.3 Гуравдугаар түвшин буюу Гүйцэтгэх захирлын хяналт

3.1.4.4 Дөрөвдүгээр түвшин буюу ТУЗ-н дэргэдэх Эрсдэлийн хороо, ТУЗ-н дэргэдэх аудитын хяналт

3.2 Оролцогч талуудын эрх үүрэг

3.2.1 Оролцогч талуудын баримтлах үндсэн зарчим

ББСБ-ын бүх ажилтан, албан тушаалтнууд өөрсдийн ажил үүргийг гүйцэтгэхэд дараах үндсэн зарчмуудыг чандлан мөрддөг байна. Үүнд:

3.2.1.1 Хууль, тогтоомж, дүрэм, журам мөрдөх. ББСБ-ын ажилтнууд Монгол Улсын хууль, тогтоомж, олон улсын гэрээ, зохицуулагч байгууллагаас баталсан дүрэм, журам, стандарт болон эдгээрт нийцүүлэн гаргасан байгууллагын дотоод дүрэм, журам, ёс зүйн дүрмийг өдөр тутмын үйл ажиллагаанд мөрддөг байх бөгөөд харилцагч, түншүүд, зохицуулагч байгууллагын шаардлага, хүлээлтэд нийцэж, ББСБ-ын нэр хүндийг ямагт өргөдөг байна.

3.2.1.2 Мэргэжлийн ёс зүйтэй байх. ББСБ-ын бүх түвшний ажилтнууд өөрийн хариуцсан ажил, албан үүргээ гүйцэтгэхдээ мэргэжлийн ёс зүйтэй байж аливаа сонирхлын зөрчил, хууль бус үйлдлээс ангид байна.

3.2.1.3 Мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах. ББСБ-ын бүх түвшний ажилтан нь өөрийн эрх мэдэл, албан үүргийн хүрээнд олж авсан харилцагч, түнш байгууллагуудын болон ББСБ-ын дотоод мэдээллийг хуульд заасан үндэслэлээс бусад тохиолдлоор бусдад задруулахгүй, ёс бусаар хувийн ашиг сонирхолд нийцүүлж ашиглахгүй байх, бусадтай солилцохгүй байна.

3.2.1.4 Сонирхлын зөрчлөөс ангид байх. ББСБ-ын бүх түвшний ажилтан нь

ББСБ-ын ашиг сонирхлыг хувийн ашиг сонирхлоос дээгүүр тавих бөгөөд аливаа шийдвэр гаргалт бусдад давуу байдал үзүүлэх үйлдлээс ангид байна.

3.2.1.5 Авлига, хээл хахуулиас ангид байх. ББСБ-ын бүх түвшний ажилтан нь ажил үүргээ гүйцэтгэхдээ аливаа хэлбэрээр бусдаас авлига, хээл хахууль авах/өгөх, давуу байдал бий болгох замаар ямар нэгэн хөнгөлөлт урамшуулал авах зэргээс ангид байна.

3.2.1.6 Зөрчлийн тухай мэдээлэх. ББСБ-ын бүх түвшний ажилтан нь ББСБ-ын дотоод хэм хэмжээ, дүрэм, журмыг зөрчсөн, ББСБ-ын ёс зүйн дүрэмд нийцэхгүй үйлдэл/эс үйлдэл гаргасан, гаргахыг завдсан этгээдийг ББСБ-ын “Ёс зүйн дүрэм”-ийн дагуу мэдээлдэг байх бөгөөд ББСБ-ын мэдээлэл өгсөн ажилтныг гадуурхахгүй, бусдаас ирэх дарамт, шахалтад орохоос урьдчилан сэргийлдэг, хамгаалдаг байна.

3.2.2 I дүгээр түвшний хяналтын нэгж буюу салбарын захирал болон ажилтнууд

ББСБ-ын нэгжийн удирдлага болон ажилтнууд нь өөрсдийн үйл ажиллагааны хүрээнд учирч болзошгүй бүхий л эрсдэлийг удирдаж, холбогдох хяналтуудыг үр дүнтэй хэрэгжүүлэх үндсэн үүргийн хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.2.2.1 ББСБ-ын харилцагчийн зээлийн данс, цахим төлбөр тооцоонд тусгайлан хяналт тавих үйл ажиллагааг зохион байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих, заавар зөвлөгөөгөөр хангах;

3.2.2.2 Эрсдэлийн бодлого, холбогдох журамд заасан шаардлага, зохицуулалтуудыг баримтлан ажиллах;

3.2.2.3 Өөрсдийн ажил үүргийн чиглэлээр, хариуцаж буй үйл ажиллагаанд хамааралтай аливаа эрсдэлийг хянах, үр ашигтай удирдах, дараалсан болон шат шатны хяналтыг хэрэгжүүлэх;

3.2.2.4 ББСБ-ын батлагдсан эрсдэлийн аппетиттай өөрийн хариуцаж буй нэгжийн эрсдэлийн аппетитийг уялдуулах, эрсдэлийн соёлыг бүрдүүлж, өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдлөг болгох;

3.2.2.5 Өөрийн хариуцаж буй нэгжийн түвшинд эрсдэлийн хязгааруудыг тогтмол хянах, шаардлагатай арга хэмжээг тодорхойлж хэрэгжүүлэх;

3.2.2.6 Материаллаг түвшний эрсдэл учирсан үед цаг алдалгүй өөрөөс шалтгаалсан арга хэмжээг авах, учирсан эрсдэлийн нөлөөллийн цар хүрээг бууруулах;

3.2.2.7 Учирсан болон болзошгүй эрсдэлийн мэдээллийг холбогдох зохицуулалтын дагуу II дугаар түвшний хяналтын нэгжүүдэд мэдээлэх, хамтран ажиллах (*бие даасан байдал болон үйл ажиллагаанд нөлөөлөхгүй байх*);

3.2.2.8 Эрх бүхий хороод болон II дугаар түвшний хяналтын нэгжүүдээс

эрсдэлийн удирдлагын чиглэлээр өгсөн чиг үүргийг биелүүлж, гүйцэтгэлийг мэдээлэх;

3.2.2.9 Эрсдэлийн удирдлага хариуцсан нэгжээс шаардсан өөрсдийн үйл ажиллагаатай холбогдох тайлан, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд хүргүүлж байх.

3.2.3 II дугаар түвшний хяналтын нэгж буюу (i) Гүйцэтгэх захирлын дэргэдэх эрсдэлийн хороо

Эрсдэлийн удирдлага хариуцсан нэгж нь эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд мониторинг хийх, хэрэгжүүлэлтэд дэмжлэг үзүүлэх, үр дүнтэй эрсдэлийн удирдлагыг дэмжсэн бодлого, журам, арга аргачлал, заавар, зөвлөмжөөр хангах үндсэн үүргийн хүрээнд дараах чиг үүргийн хэрэгжүүлнэ. Үүнд:

- 3.2.3.1 Эрсдэлийн бодлого, эрсдэлийн удирдлагын журам, заавар, арга аргачлал болон эрсдэлийн зохистой аппетитийг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавьж ажиллах (*Санхүү удирдлага хариуцсан нэгж болон Гүйцэтгэх захирлын хамтаар*);
- 3.2.3.2 Эрсдэлийг хянагч, дохиологч, тайлагнагч, зохистой удирдагч байх;
- 3.2.3.3 Олон улсын жишигт нийцсэн эрсдэлийн удирдлагын үнэлэх, хэмжих арга аргачлалыг тогтмол хөгжүүлэн боловсронгуй болгох, олон улсын тэргүүн болон шилдэг туршлагыг нэвтрүүлэх;
- 3.2.3.4 Эрсдэлийн аппетитийн хүрээнд Гүйцэтгэх захирал болон санхүүгийн удирдлага хариуцсан нэгжийн хамтаар бизнес нэгжүүдэд эрсдэлийн хязгаар үзүүлэлтийг тогтоож батлах;
- 3.2.3.5 Бизнесийн нэгжүүдийн эрсдэлийн нөхцөл байдалд бие даасан хяналт хийх, тэдгээрийн үйл ажиллагаа нь ББСБ-ын эрсдэлийн бодлого, аппетиттай нийцэж байгаа эсэхийг шалгах, баталгаажуулах;
- 3.2.3.6 Эрсдэлийг илрүүлэх, тодорхойлох, үнэлэх, хэмжих, бууруулах, эрсдэлээс сэргийлэх, хянах арга замуудыг тодорхойлох, шаардлагатай арга хэмжээний санал боловсруулж холбогдох Хороонд танилцуулан, шийдвэр гаргуулах;
- 3.2.3.7 Батлагдсан эрх үүргийн хүрээнд эрсдэлийг удирдах үйл ажиллагааг бие даан хэрэгжүүлэх, шуурхай арга хэмжээ авч ажиллах;
- 3.2.3.8 Эрсдэлийн удирдлагын чиглэлээр ББСБ-ын бусад газар нэгжүүдтэй хамтран ажиллах, зөвлөх;
- 3.2.3.9 ББСБ-ын дотоодын бодлого, дүрэм, журамд хэрэгжилтийн хяналт хийж, холбогдох эрсдэлийн дүгнэлт, санал боловсруулах;
- 3.2.3.10 Холбогдох эрсдэлийн дүгнэлт, санал боловсруулалтын хэрэгжилтэд хяналт тавих;
- 3.2.3.11 ББСБ-ын эрсдэлийн аппетитийн тайланг хагас жил тутам боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлийн хорооны гишүүдэд хүргүүлж байх, шаардлагатай тохиолдолд хорооны хуралд танилцуулах;

- 3.2.3.12 ББСБ-ын эрсдэлийн аппетиттай холбогдох эрсдэлийн үзүүлэлтийг хянах, удирдлагын мэдээллийн системийн нэгдмэл байдлыг хариуцах;
- 3.2.3.13 Холбогдох газар нэгж, ажилтнуудаас эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээлэл, холбогдох тайланг гаргуулан авах;
- 3.2.3.14 Энэхүү бодлого болон холбогдох бусад журмын хэрэгжилтэд хяналт тавих.

3.2.4 II дугаар түвшний хяналтын нэгж буюу (ii) захиргаа, эрх зүй хариуцсан нэгж.

ББСБ-ын захиргаа, эрх зүй хариуцсан нэгж нь эрсдэлийн удирдлагын тогтолцоонд дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

- 3.2.4.1 ББСБ-ын урамшууллын бодлого болон шийдвэр гаргалтын процессыг сайжруулах, энэ тухай санал гаргах, саналаа холбогдох хороогоор шийдвэрлүүлэх;
- 3.2.4.2 ББСБ-ын ажилчдын бүтээмжийг нэмэгдүүлэх, дотоод уур амьсгал болон ББСБ-н соёлыг дэлгэрүүлэх, сайжруулах тухай санал гаргаж холбогдох хороо, эрх бүхий этгээдээр шийдвэрлүүлэх, гүйцэтгэлийг хангах;
- 3.2.4.3 ББСБ-аас эрх бүхий байгууллага, аливаа хуулийн этгээд болон харилцагч, түншүүдэд хүрч буй аливаа гэрээ, албан бичиг, мэдээллийн хуульд нийцсэн эсэх, эдгээр нь хуулийн хүрээнд хүчин төгөлдөр болж буй эсэхэд хяналт тавих, санал өгөх, дохиолох;
- 3.2.4.4 ББСБ-ын нэхэмжлэлтэй эсхүл ББСБ-ыг хариуцагчаар татсан шүүх болон арбитрын шүүхийн маргаанд ББСБ-г төлөөлж оролцох, ББСБ-ын эрх ашгийн дагуу хэргийг шийдвэрлүүлэхийг зорьж ажиллах;
- 3.2.4.5 ББСБ-ын хүний нөөцийн бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх, II-р түвшний хяналтын нэгжийн дүгнэлт, зөвлөмж, үнэлгээний дагуу гүйцэтгэлийг сайжруулах;

3.2.5 II дугаар түвшний хяналтын нэгж буюу (iii) комплаенс хариуцсан ажилтан.

ББСБ-ын комплаенс хариуцсан нэгж нь эрсдэлийн удирдлагын тогтолцоонд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

- 3.2.5.1 ББСБ-ын комплаенсын бодлого, түүний цар хүрээг тодорхойлох, Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;
- 3.2.5.2 ББСБ-ын дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын хөтөлбөрийг Дотоод хяналтын нэгжтэй хамтран боловсруулах, Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулах, гүйцэтгэлд хяналт тавих;
- 3.2.5.3 Мөнгө угаах, терроризм, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны шаардлага, шалгуур болон арга аргачлалуудыг

боловсруулж дотоод журам, зааварт тусгах;

3.2.5.4 ББСБ-ын харилцагчийг таньж мэдэх, үнэлгээ хийх, эцсийн өмчлөгч тодорхойлох үйл явцад хяналт тавих, заавар зөвлөгөөгөөр хангах;

3.2.5.5 Олон улсын болон дотоодын хориг арга хэмжээг ББСБ-ын хэмжээнд хэрэгжүүлэх чиглэлээр холбогдох үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилт, гүйцэтгэлд хяналт тавих, заавар зөвлөгөөгөөр хангах;

3.2.6 II дугаар түвшний хяналтын нэгж буюу (iv) дотоод хяналт хариуцсан нэгж.

ББСБ-ын Дотоод хяналт хариуцсан нэгж нь эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд дараах чиг үүрэгтэй оролцоно. Үүнд:

3.2.6.1 Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны баримтлах бодлого, дотоод журмын хэрэгжилт, ББСБ-ын үйл ажиллагааны цар хүрээ онцлог, эрсдэлийн түвшинтэй уялдсан эсэхэд санал, зөвлөмж өгөх;

3.2.6.2 Эрсдэлийн удирдлагын үнэлгээнд ашиглаж буй аргачлалын сул тал, хязгаарлалт, тооцооны нарийвчлал, ашиглаж буй мэдээллийн найдвартай үнэн зөв эсэхэд санал, зөвлөмж өгөх;

3.2.6.3 Өмнөх аудитаар өгсөн санал дүгнэлтийн хэрэгжилтийг шалгаж, үнэлгээ, зөвлөмж өгөх;

3.2.6.4 ББСБ-ын түвшинд болон бизнесийн нэгжүүдийн түвшинд эрсдэлийн удирдлагын тогтолцоог урьдчилсан тогтоосон хуваарийн дагуу шалгах, үнэлэлт, дүгнэлт өгөх;

3.2.6.5 Эрсдэлийн хязгаарууд зөрчигдсөн болон үл хүлээн зөвшөөрөх эрсдэлийн тохиолдол бий болсон үед түүнийг таньж мэдэх, тайлагнах тогтолцоо байгаа эсэхийг тодорхойлох, дүгнэлт гаргах;

3.2.6.6 Эрсдэлийн удирдлагын тогтолцооны хэрэгжилтийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороонд хараат бусаар тайлагнах;

3.2.6.7 Эрсдэлийн аппетитийг тодорхойлоход ашиглаж буй эрсдэлийн үзүүлэлтүүдийг хэмжих арга техник болон удирдлагын мэдээллийн системийн үр ашгийг хэмжих, шаардлагатай стандартыг тогтоох;

3.2.6.8 Эрсдэлийн удирдлагын тогтолцоонд материаллаг дутагдал илэрсэн бол тухай бүр Гүйцэтгэх захиралд мэдэгдэх, шалтгааныг тодорхойлж байх;

3.2.6.9 Шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн аудитын байгууллагаар эрсдэлийн бодлого, аппетитийн хэрэгжилт болон эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр ашигтай байдлын талаар гуравдагч талын дүгнэлт гаргуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо эсхүл Гүйцэтгэх захиралд санал гаргаж/хүргүүлж байх;

3.2.6.10 Энэхүү бодлого болон холбогдох журмын хэрэгжилтийг шалгах, дүгнэлт өгөх.

3.2.7 III дугаар түвшний хяналтын нэгж буюу Гүйцэтгэх захирал

Гүйцэтгэх захирал нь ББСБ-ын эрсдэлийн удирдлагыг зохион байгуулагч байх бөгөөд эрсдэлийн соёлыг төлөвшүүлэх, ББСБ-ын үндсэн зорилтуудыг дэмжсэн үр дүнтэй эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх зорилгын хүрээнд дараах үүргийг хэрэгжүүлнэ.

- 3.2.7.1 ББСБ-ын зохистой эрсдэлийн аппетитийг тодорхойлох (*санхүү удирдлага болон эрсдэлийн удирдлага хариуцсан нэгжсийн хамтаар*);
- 3.2.7.2 Эрсдэлийг цаг алдалгүй тодорхойлох, эрсдэлийн хязгаарыг зөрчиж материаллаг хэмжээний эрсдэл учрахаас сэргийлэхийн тулд нэг болон хоёрдугаар түвшний хяналтын нэгжүүдийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо дахь нэгдмэл байдлыг хангах;
- 3.2.7.3 ББСБ-ын эрсдэлийн аппетит нь бизнесийн нэгжүүдийн үйл ажиллагаанд тусахдаа зөв тодорхойлогдсон эсэхийг санхүү удирдлага болон эрсдэлийн удирдлага хариуцсан нэгжүүдийн хамтаар тогтоох;
- 3.2.7.4 ББСБ-ын эрсдэлийн соёлыг түгээн дэлгэрүүлэх, тогтооход манлайлж оролцох;
- 3.2.7.5 Эрсдэлийн удирдлагын үр ашигтай тогтолцоог бүрдүүлэх, тогтвортой ажиллахад шаардлагатай хүний нөөц, туршлага ур чадварыг эрсдэлийн удирдлага, дотоод хяналт, мэдээлэл технологийн үйл ажиллагааны хувьд бүрдүүлэх;
- 3.2.7.6 Материаллаг хэмжээний эрсдэл учирсан үед цаг алдалгүй өөрөөс хамаарах арга хэмжээг авах, учирсан эрсдэлийн нөлөөллийн цар хүрээг бууруулах;
- 3.2.7.7 Материаллаг хэмжээний эрсдэл учирч, эрсдэлийн хязгаарыг давсан тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороонд болон шаардлагатай тохиолдолд зохицуулагч байгууллагад мэдээлэх, авч хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэх төлөвлөгөөг танилцуулах;
- 3.2.7.8 Энэхүү бодлогын хэрэгжилтэд байнгын хяналт тавих үүргийн хүрээнд бодлогыг дагаж мөрдөөгүй, зөрчсөн ажилтанд ББСБ-ын дотоод дүрэм, журам, хөдөлмөрийн гэрээний дагуу хариуцлага хүлээлгэх тогтолцоог бүрдүүлэх.

3.2.8 IV дүгээр түвшний хяналтын нэгж буюу (i) ТУЗ-н дэргэдэх Эрсдэлийн хороо

- 3.2.8.1 ТУЗ-н дэргэдэх Эрсдэлийн хороо нь ББСБ-ын эрсдэлийн удирдлагын зорилгыг тодорхойлж, чиглүүлэх үндсэн үүрэгтэй бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 3.2.8.2
- 3.2.8.3 Эрсдэлийн бодлого, эрсдэлийн аппетитийг батлах;
- 3.2.8.4 Стратегийн шинжтэй шийдвэр гаргалтуудын хувьд эрсдэлийн аппетитийн хэрэгжилтийг харгалзах;



- 3.2.8.5 Эрсдэлийн үзүүлэлтүүд болон эрсдэлийн хязгаарууд зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхэд тогтмол хяналт тавих;
- 3.2.8.6 ББСБ-ын гүйцэтгэх удирдлагын зүгээс эрсдэлийн удирдлагын чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь хангалттай бөгөөд үр дүнтэй эсэхэд хяналт тавих;
- 3.2.8.7 ББСБ-ын гүйцэтгэх удирдлагатай хамтран эрсдэлийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох, ББСБ-ын хугацааны стратеги, бизнес төлөвлөгөө, эрсдэлийн чадамж, урамшууллын бодлоготой нийцэж буй эсэхэд анхаарах;
- 3.2.8.8 Эрсдэлийн хязгаар зөрчигдсөн бол авах арга хэмжээг хэлэлцэх, авсан арга хэмжээний хэрэгжилтийг хянах;
- 3.2.8.9 Эрсдэлийг удирдах үйл ажиллагааг тухайн үеийн зах зээлийн нөхцөл байдал, хэтийн төлөв, ББСБ-ын бодлоготой уялдуулан зохицуулах талаар удирдамж чиглэл өгөх;
- 3.2.9 IV дүгээр түвшний хяналтын нэгж буюу (ii) ТУЗ-н дэргэдэх аудитын хяналт**
 - 3.2.9.1 Хараат бус баталгаажуулалтаар хяналт хийж тайлагнаж ажиллах
 - 3.2.9.2 Хараат бус аудит нь эрсдэлд суурилсан аргачлалыг ашиглаж ТУЗ-д хараат бус дүгнэлтийг гаргаж өгөх
 - 3.2.9.3 ББСБ эрсдэлийг үр дүнтэй удирдаж ажиллаж байгаа талаар I, II, III түвшний үйл ажиллагаанд хараат бус үнэлэлт дүгнэлт өгөх

ДӨРӨВ. ЭРСДЭЛИЙН ТӨРӨЛ

- 4.1 ББСБ-ын хэмжээнд дараах үндсэн эрсдэлийн төрлүүдийг тодорхойлж, үнэлж удирдана. Үүнд:
 - 4.1.1 Нийцлийн эрсдэл (Compliance Risk) гэдэг нь байгууллага хууль тогтоомж, дүрэм журам, стандарт болон ёс зүйн хэм хэмжээг мөрдөөгүйгээс үүсэх хууль эрх зүйн шийтгэл, санхүүгийн алдагдал, эсвэл нэр хүндийн хохирлыг хэлнэ.
 - 4.1.2 Санхүүгийн эрсдэл гэдэг нь байгууллагын ашигт ажиллагаа, мөнгөн урсгал, хөрөнгийн үнэлгээ, санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй тодорхойгүй нөхцөл, үйл явдлын нөлөөг хэлнэ.
 - 4.1.3 Стратегийн эрсдэл гэдэг нь байгууллагын урт хугацааны зорилгодоо хүрэх чадварт сөргөөр нөлөөлөхүйц шийдвэр гаргах, эсвэл гадаад орчны өөрчлөлтөд дасан зохицож чадахгүй байх магадлалыг хэлнэ.
 - 4.1.4 Үйл ажиллагааны эрсдэл (Operational Risk) гэдэг нь байгууллагын дотоод үйл ажиллагаа, боловсон хүчин, систем болон гаднын хүчин зүйлийн нөлөөгөөр үүсдэг алдагдал хүлээх магадлалыг хэлнэ.
 - 4.1.5 Мэдээлэл технологи, мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл гэдэг нь мэдээллийн системийн найдвартай байдал алдагдах, нууц мэдээлэл гадагшлах, эсвэл технологийн саатлаас үүдэн бизнес зогсох магадлалыг хэлнэ.

ТАВ. БУСАД

- 5.1 Эрсдэлийн удирдлага хариуцсан нэгж нь ББСБ-ын голлох эрсдэлийн тайланг улирлаар бэлтгэж дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор Гүйцэтгэх захирлын дэргэдэх Эрсдэлийн ерөнхий хороонд танилцуулж санал гаргасан тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулна.
- 5.2 ББСБ-ын ажилтнууд эрсдэлийн удирдлагын бодлого, түүнд нийцүүлэн гаргасан журам, зааврыг чанд мөрдөж ажиллана.
- 5.3 Энэхүү бодлогыг зөрчсөн, зөрчсөнөөс үүдэн ББСБ-д аливаа хохирол учирсан бол тухайн ажилтнаар хохирлыг барагдуулж, холбогдох хууль тогтоомж, дотоод журам, хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Хавсралт 1. Эрсдэлийн хязгаар.

ББСБ-ЫН ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ЭРСДЭЛИЙН ХЯЗГААР

ЭРСДЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	Эрсдэлийн түвшин				ББСБ-ын эрсдэлийн аппетит	Үл зөвшөөрөх түвшин
	Аюулт ай	Өндөр	Зохист ой	Бага		

ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ЗОХИСТОЙ ХАРЬЦАА, ТҮҮНИЙГ ХАМГААЛАХ НӨӨЦ

Нэгдүгээр өөрийн эрсдэлээр активын харьцаа	зэрэглэлийн хөрөнгө, жигнэсэн	<8%	<9%	<10%	>=10 %	Зохистой/ Бага	Аюултай
Өөрийн эрсдэлээр активын харьцаа	хөрөнгө, жигнэсэн	<16%	<18%	<20%	>=20 %	Зохистой/ Бага	Аюултай
Нэгдүгээр өөрийн активын харьцаа	зэрэглэлийн хөрөнгө, нийт	<8%	<9%	<10%	>=10 %	Зохистой/ Бага	Аюултай

ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА

Төлбөр гүйцэтгэх чадварын үзүүлэлт	түргэн	<6%	<7%	<8%	>=8%	Зохистой/ Бага	Аюултай
--	--------	-----	-----	-----	------	-------------------	---------

АКТИВ ХӨРӨНГИЙН ТӨВЛӨРЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Хөрөнгө эрсдэлийн хүрэлцээ (+илүү, -дутуу)	/актив/-ийн сангийн
--	------------------------

Нэг зээлдэгчид болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	<32%	<31%	<30%	<=30 %	Зохистой/ Бага	Аюултай
Банк бус санхүүгийн байгууллагаас гаргасан төлбөрийн баталгааны зохистой харьцаа	<80%	<75%	<70%	<=70 %	Зохистой/ Бага	Аюултай
Банк бус санхүүгийн байгууллагын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал, ажилтан, холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүнгийн зохистой харьцаа	<27%	<26%	<25%	<=25 %	Зохистой/ Бага	Аюултай
Банк бус санхүүгийн байгууллагын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал, ажилтан, холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	<12%	<11%	<10%	<=10 %	Зохистой/ Бага	Аюултай
Компанийн хувьцаа, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	<24%	<22%	<20%	<=20 %	Зохистой/ Бага	Аюултай

Компанийн өрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	<24%	<22%	<20%	<=20 %	Зохистой/ Бага	Аюултай
---	------	------	------	-----------	-------------------	---------

БУСДААС ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	<62%	<61	<60%	>=60 %	Зохистой/ Бага	Аюултай
---	------	-----	------	-----------	-------------------	---------

Өрийн бичгийн зохистой харьцаа	<32%	<31%	<30%	>=30 %	Зохистой/ Бага	Аюултай
-----------------------------------	------	------	------	-----------	-------------------	---------

** Харьцааны шалгуур үзүүлэлт бодох аргачлалыг Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 78 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	<17%	<16%	<15%	>=15 %	Зохистой/ Бага	Аюултай
--------------------------------------	------	------	------	-----------	-------------------	---------

** Харьцааны шалгуур үзүүлэлт бодох аргачлалыг Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 78 дугаар тогтоол “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-д*

СТРАТЕГИЙН ЭРСДЭЛ

Стратегийн KPI-ийн хазайлт $\pm 10\%$ - нас хэтрэхгүй	>15%	$\leq 15\%$	$\leq 10\%$	$\leq 5\%$	Зохистой / Бага	Аюултай
--	------	-------------	-------------	------------	--------------------	---------

ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ

NPL Ratio $\leq 5\%$	>7%	$\leq 7\%$	$\leq 5\%$	$\leq 3\%$	Зохистой / Бага	Аюултай
----------------------	-----	------------	------------	------------	--------------------	---------

PAR90 $\leq 7\%$	>7%	$\leq 7\%$	$\leq 3.5\%$	$\leq 3\%$	Зохистой / Бага	Аюултай
------------------	-----	------------	--------------	------------	--------------------	---------

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛ	>10	≤ 10	≤ 5	≤ 2	Зохистой / Бага	Аюултай
---------------------------	-----	-----------	----------	----------	--------------------	---------

НИЙЦЛИЙН ЭРСДЭЛ	>3	≤ 3	≤ 1	0	Зохистой / Бага	Аюултай
-----------------	----	----------	----------	---	--------------------	---------

МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ЭРСДЭЛ	>3	≤ 3	≤ 1	0	Зохистой / Бага	Аюултай
--------------------------------	----	----------	----------	---	--------------------	---------



